



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар Б/28

Баян-Овоо сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан А/35, А/10, 9 дүгээр тушаалын 3.1, 6, 8 дахь заалт, Хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.4, 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орчноо өөрчилье-хандлагаа шинэчлэе" ажлын байрын тохижилт соёлжилтын аянд идэвхтэй оролцож, номын санг шинээр засварлан тохижуулж, коридорын номын санг байгуулж албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй нэмэлт ажил үүргийг хариуцлагатай хийж гүйцэтгэсэн тул нэр бүхий албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг олгосугай.

2. Нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Ур чадварын нэмэгдлийг 20 хувиар тооцож 4 дүгээр сард олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Ч.БОЛОРМАА

2326010095